

МАК - II Үе Шат

Улс:	Монгол
Төслийн №:	41547
Бизнесийн салбар:	Байгалийн нөөц
Төрийн / Хувийн:	Хувийн хэвшил
Байгаль орчны ангилал:	А
Захирлуудын Зөвлөлийн огноо:	2011 оны 12-р сарын 6
Статус:	Захирлуудын Зөвлөлөөр зөвшөөрөгдсөн, Гарын үсэг зурагдахаар хүлээгдэж байгаа
Төслийн хураангуй нийтлэгдсэн огноо:	2011 оны 10-р сарын 6

Төслийн танилцуулга

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ) нь Монгол Улсын зүүн өмнөд хэсэгт орших Цагаан суваргын зэсийн уурхайг хөгжүүлэх (Төсөл)-д МАК компанид зээлийн санхүүжилт хийх асуудлыг судалж байна.

Шилжилтийн үйл явцад үзүүлэх нөлөөлөл

Уг Төсөл нь Монгол улсын уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих өргөн хүрээтэй үйл ажиллагааны нэг хэсэг юм. Энэхүү үйл ажиллагааны гол зорилтууд нь:

Хувийн хэвшийн хөгжлийг дэмжих

Санал болгож буй санхүүжилтээр Банк нь МАК компанийг дотооддоо амжилттай хөгжин олон улсын зах зээл дээр амжилттай өрсөлдөх чадвартай компани болоход нь дэмжлэг үзүүлэх юм. Энэхүү Төсөл нь шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлснээр өөрийн бизнесээ өргөжүүлэх боломжийг МАК-д олгоно.

Ил тод байдал, бизнесийн болон байгаль орчны удирдлагын хувьд стандартууд тогтоох

Энэхүү Төсөл нь компанийн үйл ажиллагаан дахь төрөл бүрийн чиглэлийн стандартуудыг сайжруулна. Үүнд:

- Уурхайг хаах төлөвлөгөө болон Байгаль Орчин Нийгмийн Үйл ажиллагаанд хийгдэх ажлын төлөвлөгөө (БОНУАХАТ)-г боловруулах асуудлыг санхүүжилтын гэрээнд зохих болзол болгон оруулж өгөх замаар уг Төсөл нь Компанийн байгаль орчин, нийгмийн менежментийн стандартыг сайжруулахад тусална;
- Энэхүү Төсөл нь МАК болон Банкны хамтарсан санхүүжилтээр үзүүлэх ТАМ/BAS техникийн туслалцаагаар дамжуулан тухайн уул уурхайтай холбоотой бизнес эрхлэгчдийг дэмжих, орон нутгийн компаниудыг чадваржуулах замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих болно;
- энэхүү Төсөл нь Олборлох үйлдвэрүүдийн ил тод байдлын санаачлагыг (дэлгэрэнгүй мэдээллийг “Техникийн хамтын ажиллагаа” хэсгээг үзнэ үү) тус улсад дэлгэрүүлэх, үргэлжлүүлэн дэмжих чиглэлээр чухал алхам болох юм.

Харилцагч

Монголын Алт Корпораци ('МАК' эсвэл 'Компани') хэмээх Монголын хувийн хэвшлийн уул уурхайн компани.

ЕСБХБ-ны санхүүжилт

Банкны санхүүжилт нь үе шатлал бүхий нөхцөлт зээл байна.

Төслийг хэрэгжүүлэхэд зориулж 350 сая ам.долларын нөхцөлт зээл, мөн 100 сая ам.долларын нэмэлт санхүүжилт төсөвлөгдсөн.

Төслийн нийт өртөг

869 сая ам.доллар

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Байгаль орчны ангилал болон үндэслэл

Уг Төсөл нь А ангилалд багтсан тул Банкны шаардлагын дагуу Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг (БОННБҮ) хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.

Байгаль орчны гол асуудлууд болон нөлөөллийг бууруулах талаар

БОННБҮ-г Компанийн зөвлөхүүд Банкны шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэсэн. Төслийн судалгаа болон БОННБҮ-г хийх явцад гарсан үнэлгээ ба гол асуудлуудыг Төсөлд оролцогч бүх талуудтай зөвлөлдсөн болно.

БОННБҮ-ний явцад тогтоогдсон гол асуудлууд нь дараах хэдэн зүйл байлаа. Үүнд:

- **Ус** – Гадаргуугийн болон гүний ус. Тус уурхай байгуулагдах газар нь усны эх үүсвэр ховортой мөн орон нутгийн хүн ам болон ургамал, амьтанд ус чухал байдаг Монгол улсын зүүн өмнөд хэсэгт оршдог. Төслийн төлөвлөгөөнд уурхайгаас 16 км болон 50 км зайтай тогтоогдсон хоёр усны цооногоос ус татах бололцоотой гэж тусгагдсан ба тухайн цооногийн замыг гаргахдаа малчдын аливаа худагт аль болох бага нөлөө үзүүлэхээр хийх болно.
- **Уурхайн дэд бүтэц** - ил уурхай, хаягдал хүдэр хадгалах байгууламж болон хаягдал чулуулаг овоолох газар зэрэг нь хөрс болон усны чанарт нөлөөлж болох аюултай бодис ялгаруулах боломжтой. Тиймээс эдгээр байгууламжуудаас усны урсгалыг холдуулан зайлуулж, аюултай байж болзошгүй материалуудыг зохих ёсоор битүүмжлэн хадгалснаар уг нөлөөллийг бууруулах болно;
- **Хаягдлын менежмент** – төслийг хэрэгжүүлэх явцад уурхайн талбайн ойролцоо хаягдал чулуулаг болон хаягдал хүдэр их хэмжээгээр хуримтлагдана. Тиймээс Европын Холбооны стандартын дагуу хаягдал хүдрийн хадгалах байгууламж, хаягдал чулуулгийн овоолго болон хог булах газрууд нь агаар дамжуулахгүй битүүмжлэл бүхий баригдах болно;
- **Ургамал ан амьтад** – Говь нь ховордож буй хулан, бөхөн, шонхор шувуу мэтийн ан амьтад ургамлын өлгий болсон нутаг. Уул уурхайн үйл ажиллагаа, уурхайн зам, гадаад руу тээвэрлэх зам зэрэг туслах дэд бүтцийг ургамал, ан амьтанд нөлөөлөх нөлөөлөл хамгийн бага байлгахгаар сонгон төлөвлөсөн болно. Хуулагдсан өнгөн хөрсийг эргэн нөхөн сэргээлт хийж ургамалжуулах бололцоотой байхаар хадгалснаар ургамалжилтанд үзүүлэх нөлөөллийг бууруулна;
- **Нийгэмд нөлөөлөх байдал** – тус уурхай нь орон нутагт ажил эрхлэлтийг бий болгох боловч дэд бүтэц барьж байгуулах газар руу хүмүүсийг нүүн шилжихэд хүргэнэ. Мөн уурхайн газар нутгийн зарим хэсэг нь зарим малчдын бэлчээрийн бүстэй давхцах боломжтой.

Лээр дурдснаас гадна өнгөн хөрсний менежмент, тоосжилтын нөлөөлөл болон Монгол улсын соёлын үнэт зүйлсэд үзүүлэх нөлөөлөл зэрэг асуудлууд БОННБҮ-ний явцад тогтоогдсон.

Уг Төсөл нь зураг төслийн үе шатандаа яваа бөгөөд байгаль орчин ба нийгмийн асуудлаарх анхан шатны судалгаанууд хийгдсэн боловч Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг дуусгавар болгоход шаардлагатай зарим нэмэлт судалгаа хийх чиглэлүүдийг БОННБҮ нь тодорхойлон гаргаж өгсөн.

Үнэлгээний явцад тогтоогдсон асуудлуудын нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд тодорхойлогдсон. Нөлөөллөөс бүрэн зайлсхийх аргагүй зарим хэсэгт нөлөөллийг бууруулах төлөвлөгөө боловсруулсан бөгөөд Төсөл хэрэгжих явцад уг төлөвлөгөө улам боловсронгуй болж асуудлуудыг шийдэн нөлөөллийг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах болно. Түүнчлэн, уг Төслийн бүхий л хугацааны туршид нөлөөллийг дахин үнэлж, нөдөөллийг бууруулах арга хэмжээ нь зөвшөөрөгдсөн хэмжээнд нөлөөллийг бууруулж чадаж байгаа эсэхийг хянаж байх хяналтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх болно.

Байгаль Орчин Нийгмийн Үйл ажиллагаанд хийгдэх ажлын төлөвлөгөө (БОНУАХАТ)-ний товч танилцуулга

Компани нь уг Төслийг хэрэгжүүлснээс үүдэн гарах байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах талаар хэд хэдэн үүрэг авч, зохих ажлуудыг хийхээр боллоо. Тухайлбал:

Төлөвлөгдөж буй ил уурхай болон уурхайтай хамааралтай бусад байгууламжуудын байршлыг дайран гарах ус, гадаргуугийн түр зуурын усны гольдролуудыг тэдгээр уурхайн байгууламжуудаас өөр тийш өөрчлөхдөө урсгалын доор байрлах гадаргуугийн болон бусад гүехэн гүний ус хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага байхаар тооцон хийнэ.

Орон нутгийн малчид болон зэрлэг ан амьтдад чухал болох гүний болон гадаргуугийн усны эх үүсвэрүүдэд нөлөө үзүүлэх эрсдлийг хамгийн бага байлгах төлөвлөгөөтэй хослуулан уурхайд үнэлгээ хийх, усны цооногийн талбайн сонголттой холбоотой гидрогеологийн цаашдын судалгаанууд явуулах үүргийг Компани хүлээсэн болно.

Компани нь өнгөн хөрсний менежмент, тоосжилтын менежмент, болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөө, ил уурхай, карьерын сонголтын төлөвлөгөө, оролцогч талуудын хамтран ажиллах төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө зэргийг боловсруулаад байна. Уг Төсөл нь боловсруулалтын шатандаа байгаа бөгөөд цаашид өөрчлөгдөх зүйлс гарах тул Өөрчлөлтийг удирдах төлөвлөгөөг мөн боловсруулсан.

Ургамал, амьтдын судалгааны хувьд компани нь өнөө хүртэл цуглуулсан өгөгдлүүдийн санг бүрэн хэмжээний болж дуусгах ажлыг гүйцэтгэх үүргийг хүлээсэн болно. Түүнчлэн Компани нь говьд үйл ажиллагаагаа явуулж буй бусад уурхайнууд, үйлдвэрийн газруудтай хамтран говийн ургамал, ан амьтдыг бүс нутгийн хэмжээнд судлах боломжийг хайхаар төлөвлөсөн.

Хяналт ба тайлан

Компани нь үндэсний хууль тогтоомжийн дагуу өөрийн уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчны нөлөөллийг хянаж байх болно. Банк нь Төслийн хэрэгжилтийн явцад боловсруулсан жил бүрийн тайланг хянан үзэх замаар Төслийн бүх хугацааны туршид байгаль орчны болон нийгмийн шаардлагуудад хэр нийцэж байгааг хянаж ажиллана. Банк жил бүр уурхайн талбайд очиж үзэн төсөлтэй танилцах болно.

Энэхүү Төслийн БОННБҮ-г доорх линк-ээр орж үзнэ үү.

Техникийн хамтын ажиллагаа

Уул уурхайн салбарт тус Банкнаас үзүүлж буй техникийн туслалцаа болох Монголын олборлох үйлдэрүүдийн ил тод байдлын санаачлагыг дэмжих төсөлд 500,000 Евро зарцуулахаар төлөвлөгдсөн.

Компанитай холбоо барих

Монголын Алт Корпораци МАК
Баянзүрх дүүрэг, шуудангийн хайрцаг 237,
Улаанбаатар 210349, Монгол улс

Бизнес хамтын ажиллагаа

Бизнесийн боломжууд болон худалдан авалттай холбоотой асуудлаар харилцагч компанитай холбоо барина уу.

Ерөнхий лавлагаа авах

ЕСБХБ-наас төсөлтэй холбоотой лавлагаа (ажил үйлчилгээ худалдаж авахтай холбоогүй) авах хаяг:
Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380
Электрон шуудан: projectenquiries@ebrd.com

Олон Нийтэд Мэдээлэх Журам (ОНМЖ)

ОНМЖ нь ЕСБХБ-аас өөрийн баримталж буй стратеги, журмууд болон явуулж буй үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх зорилгоор мэдээллийг хамааралтай этгээдэд хэрхэн түгээх, тэдэнтэй зөвлөлдөх үйл ажиллагааг зохицуулна. ОНМЖ-ыг доорхи холбоосоос үзнэ үү: [Text of the PIP](#)

Хараат Бус Санал Гомдлын Механизм (ХБСГМ)

Тус Банкны төсөл нь хөндөнгийн хувь хүн, иргэн болон байгууллагад сөргөөр нөлөөлж болзошгүй тохиолдолд тэдэнд хараат бус байдлаар санал гомдол тавих боломжийг олгох зорилгоор ЕСБХБ-аас Хараат Бус Санал Гомдлын Механизм (ХБСГМ)-ийг бий болгосон. Санал гомдол хүлээн авах, шийдвэр журмыг дараах холбоосоос үзнэ үү: www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf

Банкны санхүүжилт хийгдсэнээс хойш 12 сарын хугацаанд санал гомдлыг хүлээн авна. Банкны санхүүжилт хийгдсэн хугацааны талаар ХБСГМ-ийг хариуцсан мэргэжилтэнтэй pcm@ebrd.com хаягаар эсвэл харьяа Банкны Төлөөлөгчийн Газартай холбогдож тодруулна уу.

Энэхүү Төслийн товч танилцуулга нь Банкны Захирлуудын Зөвлөл уг Төслийг хэлэлцэхээс өмнө боловсруулан гаргагдсан. Энэхүү баримт бичгийг гаргаснаас хойш уг Төсөлд өөрчлөлт гарсан байж болох бөгөөд уг баримт бичиг нь Банкны албан ёсны баримт бичигт тооцогдохгүй болно.

Хамгийн сүүлд 2011 оны 10-р сарын 6-нд шинэчилсэн.